

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

7-Р САРЫН 21, 2020

Эдийн засгийн судалгааны алба

Нээлттэй жижиг эдийн засагтай Монгол улсад дэлхийн нийтийг хамарсан цар тахал хүчтэй нөлөөлж байна. Цар тахал нь 2020 оны хувьд эдийн засгийн том шок болов. Эдийн засгийн үзүүлэлтүүд огцом унаж, 2020 оны 1-р улиралд Монголын эдийн засаг 10.7 хувиар агшив. 2020 оны эхэнд хил хааснаар экспорт зогсож, улмаар уул уурхайн салбар 29 хувиар унасан нь голлон нөлөөлж байна. Уул уурхайн салбар зогссоноор түүнийг дагасан уул уурхайн бүс салбартаа ч нөлөөлөв.

Инфляц. Жилийн инфляцийн түвшин 2.8 хувьд хүрсэн нь эдийн засгийн идэвхжил саарч буйг илтгэж байна. Ялангуяа дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ үнэ, хөл хориотой холбоотой зарим үйлчилгээний салбаруудын(үзвэр үйлчилгээ, аялал жуулчлал) үнэ буурсан зэрэг нь тус тус нөлөөлж байна.

Монгол улсын экспортын орлого 2020 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 28 хувиар буурсан байна(голлон зэс, нүүрс). 2018, 2019 оны эхний хагаст зэсийн баяжмал дунджаар 681 мянган тонныг экспортолж байсан бол 2020 онд 626 мянган тонн болж буурсан байна. Энэ нь хилийн хоригоос гадна Оюутолгойн зэсийн баяжмал дахь зэс, алтны агууламж багассантай холбоотой. Харин нүүрсний хувьд 2018, 2019 оны эхний хагаст дунджаар 22 сая тонн экспортолж байсан бол 2020 оны эхний хагаст ердөө 9.7 сая тонн гарчээ. Олон улсын зах дээр коксжих нүүрсний үнэ 25 орчим хувиар унаж, 146 ам.доллартай тэнцэж байгаа бол зэсийн үнэ эргэж сэргэн 5700 ам.долларт хүрээд байна.

Харин ипмортын хувьд өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурчээ. Уул уурхайн салбар буурч байгаа нь шатахуун болон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортод хүчтэй нөлөөлж байна. Түүнчлэн иргэд хэмнэлтийн горимд шилжиснээр удаан эдэлгээтэй барааны импорт болох автомашин 34 хувь, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл 9 хувиар тус тус буурсан байна.

ЭЗ Агент	Үзүүлэлт	Нэгж	2019.Q1	2019.Q4	2020.Q1	YoY /2020/
Бодит сектор	Бодит ДНБ өсөлт	%	7.2%	5.1%	-10.7%	-18 p.p
	Уул уурхайн бүс ДНБ	%	6.7%	6.4%	-4.3%	-11 p.p
	Уул уурхайн ДНБ	%	14.4%	0.4%	-29%	-
	Ажилгүйдлийн түвшин	%	10.1%	8.1%	6.6%	-4 p.p
	Ажилтай иргэд	Мян.хүн	1,162	1,188	1,170	0.7%
			2019.Q2	2019.Q4	2020.Q2	YoY /2020/
Мөнгөн ий бодлого	Инфляци	%	8.3%	5.2%	2.8%	-5.5 p.p
	Мөнгөний нийлүүлэлт	Их наяд ₮	20.2	20.8	21.2	5%
	Бодлогын хүү	%	11%	11%	9%	-2 p.p
	Ханш (MNT/USD)	₮	2,654	2,727	2,816	6.1%
Сангийн бодлого	Төсвийн орлого	Их наяд ₮	4.9	10.8	4.1	-16.3%
	Төсвийн зардал	Их наяд ₮	4.7	11.5	6.3	34.4%
	Төсвийн тэнцэл	Их наяд ₮	0.2	-0.6	-2.2	-
Гадаад сектор	Экспорт	Тэрбум ₮	3.9	7.1	2.8	-28.2%
	Импорт	Тэрбум ₮	2.9	6.1	2.5	-15.2%
	Худалдааны тэнцэл	Тэрбум ₮	1.05	1.4	0.4	-65%
	Төлбөрийн тэнцэл /5-р сар/	Сая \$	234	453	-1,131	-
	ГШХО/5-р сар/	Сая \$	777	2,316	581	-25.2%
	ГВАН	Сая \$	3,706	4,349	3,203	-13.6%

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Олон улсын байгууллагуудын 6-р сарын таамаглалаас харахад цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засаг 2020 онд дунджаар 1-2 хувиар агшиж, 2021 онд дунджаар 4-5 хувиар өсөх төлөвтэй байна. Санхүүгийн салбарын нөхцөл байдалтай уялдуулан Голомт банк эдийн засгийг 2020 онд 3 хувиар агшиж, 2021 онд 5.1 хувиар өсөх төлөвтэй гэж хүлээж байна. **Уул уурхайн салбарын өсөлтийн саарахад 3 томоохон хүчин зүйл нөлөөлж байна.**

- Нэгдүгээрт, ОТ-н далд уурхайн шууд хөрөнгө оруулалт 250 орчим сая ам.доллараар буурч ойролцоогоор 1 тэрбум ам.доллар болох төдийгүй, баяжмал дахь алтны агууламж багасч байгаа зэрэг нь 2019 оны нөхцөл байдлаас төдийлөн сайжрахгүй гэж харж байна.
- Хоёрдугаарт, 2020 оны эхнээс хилийн хөл хорионы улмаас түүхий эдийн экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байна. Өдөрт дунджаар 1500 орчим машин гардаг нүүрсний гол боомтоор 4-р сарын байдлаар 700 гаруй машин гарч байгаа нь одоо ч 2 дахин бага үзүүлэлт юм.
- Гуравдугаарт, цар тахлын нөлөөгөөр гадаад нөхцөл байдлаас хамааран нүүрсний үнэ буурч байгаа нь 2020 оны экспортод сөргөөр нөлөөлөхөөр байна.

Харин уул уурхайн бус салбарын өсөлт нь төрөөс дэмжлэгтэй салбаруудаас голлон хамаарахаар байна. Тухайлбал, 2020 оны 3.5 их наяд төгрөгтэй тэнцэхүйц төсвийн хөрөнгө оруулалтын зардлын нөлөө нь тус салбаруудын өсөлтийг дэмжинэ гэсэн үг. Цаашлаад ЗГ-н хөрөнгө оруулалтын зардалтай холбоотойгоор хөрөнгө оруулалтын импорт болох барилгын материал, техник, тоног төхөөрөмж, эд анги нэмэгдэхээр байгаа нь худалдааны секторыг дэмжинэ гэж үзэж байна. Гэсэн хэдий ч ихэнх уул уурхайн бус үйл ажиллагаа эрхлэгчид засгийн газрын хагас өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас тодорхой бус байдалд байна.


Үзүүлэлтүүд	2018	2019	2020*			2021*
	Actual		Projection			
			Pre Covid-19	Post Covid, scenario until Q3	Post Covid, scenario until Q4	
Бодит сектор						
Эдийн засгийн өсөлт	7.2%	5.1%	5.2%	-1.0%	-3.0%	5.1%
Хөдөө аж ахуй	4.5%	8.4%	3.5%	2.0%	1.0%	3.5%
Аж үйлдвэр(уул уурхай оруулсан)	7.9%	2.9%	4.2%	-0.7%	-1.8%	4.0%
Үйлчилгээ	7.5%	5.9%	7.6%	1.1%	-1.4%	6.2%
Мөнгөний зах						
Инфляц	8.1%	5.2%	8.2%	6.2%	3.0%	8.1%
Мөнгөний нийлүүлэлт, их наяд ₮	19.5	20.8	22.3	21.3	21.3	22.5
Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт	23%	6.7%	7.0%	2.3%	1.7%	5.6%
Бодлогын хүү	11%	11%	13%	9%	9%	10%
Гадаад сектор						
Төлбөрийн тэнцэл, сая ам.долл	-141.7	44.0	-480	-1,240.0	-1,758.0	-730.0
Нүүрсний үнэ, ам.долл	94	78	90.0	65	65	68
Зэсийн үнэ, ам.долл	6,530	6,010	6680	5,200	5,200	5,500

Source: Pre Covid-19- Цар тахлаас өмнөх 2020 оны таамаглал

Post Covid-19, scenario until Q3- 2020 оны 3-р улиралд цар тахал намжиж, хагас өндөржүүлсэн бэлэн байдалд байна


Post Covid-19, scenario until Q4- 2020 оны эцэст цар тахал намжиж, хагас өндөржүүлсэн бэлэн байдалд байна

Эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистик хороо


Улсын төсвийн тэнцэл




Мөнгөний нийлүүлэлт




Инфляци



Гадаад худалдааны тэнцэл




Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалт

■ Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Хуримтлуулсан, Сая ам.доллар/
—■ Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Тухайн сарын, Сая ам.доллар/



Гадаад валютын нөөц




Эх сурвалж: Монголбанк

Улсын гадаад өр


■ Гадаад өр /Сая ам.доллар/ ■ Улсын гадаад өр болон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа



Ам.долларын ханш



Хүү



Эдийн засгийн судалгааны алба:

Шинжээч
Г.Батзориг
Имэйл: Batzorig_g@golomtbank.com

Шинжээч
Э.Батхорлоо
Имэйл: Batkhorloo@golomtbank.com

Эх сурвалж
1212.mn
mongolbank.mn
Голомт банкны дотоод эх сурвалж

Голомт банкны эдийн засгийн судалгааны алба нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг дотоод ажилчид, харилцагчид болон олон нийтэд хүргэн ажилладаг. Тус тайланд 2020 оны 5, 6-р сарын тоон мэдээлэл болон зарим тохиолдолд 2019 оны 4-р улирлын тоон мэдээллийг ашигласан болно. Энэхүү судалгаа нь зөвхөн банкны дотоод хэрэгцээнд зориулсан бөгөөд Голомт банкны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.

Улаанбаатар хот
2020 оны 7-р сар